

ХХ зууны монгол хүний нэрийн сан дахь зарим түүхэн хүмүүсийн нэрийн тухай

Ц.Сувд
МУИС. МХСС

Товчлол.

Монгол хүний 2 сая 300 мянган нэрийн түүвэрт байгаа түүхт хүмүүсийн нэрийг тодорхойлж, түүний цаг хугацааны хувьслыг нь авч үзэв. Ойролцоогоор 200 хүний нэрэнд нэг түүхэн хүний нэр тааралдаж байна. Нэрийн давтамжийн өөрчлөлтөөс харахад Монгол улс социализм байгуулах зорилт тавьж байсан жилүүдэд тэр үеийн Монгол, Зөвлөлтийн удирдагчид, аж ахуй, нийгэм соёлын томоохон зүтгэлтийн нэр олонтоо давтагдаж байсан бол 1990-ээд оноос Монгол улс ардчиллын замыг сонгож, үндэсний ухамсар сэргэсэн нийгмийн үйл явцтай холбогдсон Их Монгол улсын хаад, хатад, жанжнууд, үндэсний тусгаар тогтолын төлөө тэмцэгч эх орончдын нэрийг илүү сонирхох болсныг тоон үзүүлэлтээр харуулсан.

Хүний нэрийг судалсан нэр зүйч эрдэмтэд “... хүний нэр бол ард түмний түүхийн нэгэн хэсэг” [1:112], “Хүний нэр нь хүн төрөлхтөний соёлын салшгүй хэсэг бөгөөд тухайн ард түмний болон хэлнийх нь түүхэнд олон зүйлийг хэлж өгч чадна” [2:6] гэсэн дүгнэлтүүд хийсэн байдаг. Энэ дүгнэлтүүд монгол хүний нэрэнд ч нэгэн адил хамаарах бөгөөд учир нь аливаа үндэстний үр хүүхэддээ нэр өгөх зан заншилд түгээмэл зүйл олон байдаг. Нэр судлаач эрдэмтэн Ж. Сэргээ монгол хүний нэрийн санг:

1. Монгол хүний нэрийн үндсэн сан
2. Монголчуудын түүхийн тодорхой үеийн онцлог бүхий нэр


гэж 2 үндсэн хэсэгт хуваагаад ”монголчуудын түүхийн тодорхой үеийн онцлог бүхий нэрийг нь үндэс болгож, эртний монгол хүний нэр, дунд үеийн монгол хүний нэр, орчин үеийн монгол хүний нэр хэмээн үечлэн судалж болохоос гадна ХХ зууны монгол хүний нэрийн онцлогийн тухай ч ярих боломжтой юм. Өөрөөр хэлбэл саяхан өнгөрсөн ХХ зууны монголчуудын түүх хүний нэрэнд нь ямар ул мөр үлдээсэн тухай ярих тодорхой баримтууд байгаа юм” [3:98-99] гэжээ.

ХХ зуунд буюу 1900-2000 оны хооронд төрсөн 2 сая 300 мянган монгол хүний нэрийн түүвэрт ажиглалт судалгаа хийж үзвэл монгол улс, эх орон, ард түмнийхээ төлөө амьдралаа зориулж, мартагдашгүй гавьяа байгуулсан түүхэн хүмүүсийн нэр цөөнгүй тохиолдож байна. Ийнхүү түүхэн тодорхой хүмүүсийн нэрээр өөрсдийн үр хүүхдээ нэрлэдэг нь тэдгээр хүмүүс шиг баатарлаг үйлстэй, ард түмэн, төр улс, овог элгэндээ үүрд дурсагдан явах сайн хүн болохыг ерөөсөн гүн гүнзгийн утга агуулгатай юм. Тийм болохоор түүхэн гавьяат хүмүүсийн нэрээр нэрлэх ёс урьд өмнө ч байсан, ХХ зууны монголчуудын дунд ч байсан, цаашид ч байсаар байх нь тодорхой билээ.

Бидний судалгаа хийж буй ХХ зууны монгол хүний нэрийн санд Чингис, Тэмүүжин, Ван хаан, Есүхэй баатар, Мандуул, Бат, Мөнх, Хубилай, Тогоонтөмөр зэрэг хаадын нэр, Монголжингоо, Гоомарал, Өэлүүн, Бөртэ, Есүй, Есүгэн, Хулан, Мандухай Ану гэх мэт хатдын нэр, Хасар, Бэлгүүдэй, Шихихутаг, Зүчи, Цагаадай, Өгөдэй, Сүбээдэй, Мухулай гэх мэт Чингис хааны үр хүүхэд, дүү нар, шадар жанжнуудын нэр олонтоо тохиолдож байна. Түүнчлэн Сүхбаатар, Чойбалсан нараас эхлэн ХХ зууны монгол улсын удирдагчид, монгол улсын баатар, хөдөлмөрийн баатруудын нэр ч цөөнгүй байна. Эдгээр болон бусад түүхэн хүмүүсийн нэр, ХХ зууны монгол хүний нийт нэрийн 0.5 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл ойролцоогоор 200 хүний дотор түүхэн хүний нэртэй нэг хүн тааралдаж байна гэсэн үг.


Чингис хааны эцэг, Хамаг монгол аймгийн тэргүүн Есүхэй баатрын нэртэй хүн одоо 117 байна. Энэ нэрийг 1959 онд төрсөн хүүхдэд анх өгсөн байгаа нь 1956 онд

ЗХУ-ын коммунист намын 20-р их хурал хуралдаж Н.С. Хрущевын “дулаарлын” үйл явц эхэлж, нийгмийг ардчилах талаар мэдэгдэхүйц алхам хийсэн он жилүүдтэй тохирч байна. Үүнээс хойш 1960-1969 онд төрсөн 1, 1970-79 онд төрсөн 4, 1980-89 онд төрсөн 10, 1990-2000 онд төрсөн 101 хүн бүртгэгдсэн байна (1-р зураг). Есүхэй гэсэн дан нэрээс гадна Есүхэйбаатар, Есүхэймэргэн, Есүхэйтөмөр гэсэн нийлмэл нэр ч өгч байжээ.



1-р зураг. Есүхэй (Хэвтээ тэнхлэгт он, босоо тэнхлэгт тухайн нэртэй хүний тоог тэмдэглэв).


Чингис хааны багын нэр болох Тэмүүжин нэртэй 2208 хүн Монгол улсад байна. Энэ нэрийг 1923 онд төрсөн хүүхдэд эхэлж өгсөн бол 2000 онд төрсөн 181 хүүхэд Тэмүүжин нэртэй байна. Энэ нэрийн оны давтамжийг судалж үзвэл: 1920-29 онд 1, 1930-39 онд 1, 1940-49 онд 3, 1950-59 онд 2, 1960-69 онд 19, 1970-79 онд 64, 1980-89 онд 409, 1990-2000 онд 1709 хүнд энэ нэрийг өгчээ (2-р зураг).



2-р зураг. Тэмүүжин

Их Монгол улсыг байгуулсан эзэн богд Чингис хааны нэртэй 385 хүн байна. Энэхүү Чингис гэдэг нэр 1933 онд төрсөн хүүхдийг нэрлэснээр эхэлж байна. Энэ нэрийн оны давтамжийг судлан үзвэл: 1930-39 онд 2, 1940-49 онд 3, 1950-59 онд 5,


1960-69 онд 23, 1970-79 онд 53, 1980-89 онд 111, 1990-99 онд төрсөн 188 хүн Чингис нэртэй байна (3-р зураг). Чингис гэдэг нэрийг дангаар нь хүүхдэд өгөхөөс гадна нийлмэл нэрийн эхэнд буюу төгсгөлд оруулж хоёр үгээс бүтсэн нэр үүсгэж өгсөн тохиолдол олон байна. Тухайлбал Чингисбаатар, Чингисхан Чингисдалай, Чингисболд, Чингисдорж, Чингисжаргал, Чингисбаяр, Чингисхүү, Чингистөр, Чингис-Од, Чингисхас, Чингисбилгүүн, Чингисбодь, Чингисмаа, Чингистөгөлдөр, Чингисмягмар, Чингиснамжил, Чингисжав, Чингистамир, Батчингис, Мөнхчингис, Хангайчингис, Эрдэнэчингис, Энхчингис, Оюунчингис, Ганчингис, Наваанчингис, Дарханчингис, Ариунчингис, Алтанчингис, Мөнгөнчингис, Чулуунчингис, Наранчингис, Одончингис, Шинэчингис гэсэн 35 нийлмэл нэр үүсчээ.



3-р зураг. Чингис

Их Монгол улсыг эмхлэн байгуулсан их эзэн Чингис хааны нэрийн оны давтамжаас харвал Чингис, Тэмүүжин, Есүхэй нэртэй хүмүүс жилээс жилд тасралтгүй өссөн нь харагдаж байгаагийн дээр 1990-ээд оноос эрс олон болсон байна (1.2.3-р зураг). Энэ нь 1990 ээд оноос Монгол улс нэг намын дэглэм, коммунист үзэл суртлын хүлээсийг халж ардчиллын замд орсон, ард түмэн эх түүхээ үнэн бодитоор харж үндэсний үзэл, үндэсний баҳархал нь сэргэсэн нийгмийн өөрчлөлтийн шууд үр дүн юм. МАХН ын Төв Хорооноос “БНМАУ-ын түүх, утга зохиолыг сургуулиудад зааж байгаа байдлын тухай”/1949/, “Манай намын бодлогод харш үзэл санаа, уг үгүүлэл гарч байгаа тухай” /1956/, “Б.Ринчингийн сүүлийн үеийн зохиолуудад гарч байгаа зарим харш үзэл санааны тухай” /1959/, “Д.Төмөр-Очироос намын эсрэг үйлдсэн ажил явууллагын тухай” /1962/ зэрэг тогтоолуудыг удаа дараа гаргаж монголчуудыг үндэсний үзэл гэгчээр айлган дарамталж, их эзэн Чингис хааныг эзлэн түрэмгийлэгч, цуст алуурчин гэсэн үзлийг хүчээр тулгаж байсан бэрх цаг үед ч гэсэн монголын ард түмний зүрх сэргэлд их эзэн хаан маань оршсоор, нэр хүнд нь өссөөр байсныг дээрх тоо баримт гэрчилнэ.

Монголчуудын зүрх сэтгэлд зөвхөн Чингис хаан баттай байр суурь эзлээд зогсоогүй түүний эх, дүү нар, хүүхдүүдийн нэр нь ч мөнхжин үлдсэнийг дараах нэрс харуулж байна. Их Монгол улсын хоёр дахь их хаан, Чингисийн гуравдугаар хөвгүүн Өгөдэйн нэртэй 100 хүн байна. 1947 онд төрсөн хүүхдийг анх Өгөдэй гэж нэрлэжээ. Энэ нэрийн оны давтамжийг судлан үзвэл 1940-49 онд 1, 1950- 59 онд 2, 1960- 69 онд 3, 1970 -79 онд 8, 1980- 89 онд 20, 1990-99 онд 66 хүнд өгсөн байна (4-р зураг). Өгөдэй хааны нэрийг Өгэдэй, Өгөдэй, Өгөдэй, Өгүдэй, Өгөдий, Өгээдий гэж 7 янзаар бичиг баримтад бичсэн байна.



4-р зураг. Өгөдэй

Чингис хааны ууган хөвгүүн Зүчи хааны нэртэй 32 хүн, дунд хөвгүүн Цагаадайн нэртэй 31 хүн, отгон хөвгүүн Тулуйн нэртэй 16 хүн байна. Есүхэй баатрын хүү Бэлгүүдэй ноёны нэртэй 99 хүн байна. Есүхэй баатрын 2-р хүү бөгөөд Чингис хааны дүү хавт Хасарын нэртэй 53 хүн байна.


Зүчи хааны 2-р хөвгүүн Бат хаанаар нэрлэгдсэн Батхаан гэсэн нийлмэл нэртэй 66 хүн байна. Үүнээс гадна Бат нэртэй 2262 хүн байгааг дашрамд дурддяа. Өгөдэй хааны ууган хөвгүүн Гүюг хааны нэртэй 2 хүн байна. Тулуйн хөвгүүн Мөнх (1209-1258) хаанаар нэрлэгдсэн Мөнххаан гэсэн нийлмэл нэртэй 5 хүн байна. Үүнээс гадна Мөнх нэртэй 1326 хүн байна. Мөн Тулуйн хөвгүүн, Их Юан гүрнийг байгуулсан Хубилай хааны нэртэй 13 хүн байна.

Чингис хааныг төрүүлсэн эх, түүний хамгийн дотно, ухаалаг зөвлөгч Өлөн эхийн нэртэй 19 хүн байна. 1925 онд төрсөн хүүхдийг анх Өлөн гэж нэрлэжээ. Энэ нэрийг 1920- 29 онд 1, 1950-59 онд 1, 1970- 79 онд 1, 1980- 89 онд 2, 1990-2000 онд 14 хүүхдэд өгчээ.

Монголын Нууц Товчоонд гардаг Чингис хааны дээд язгуур Бөртэ чонын гэргий Гоомаралын нэртэй 226 хүн байгаагийн 184 нь 1990 оноос хойш төрсөн охидын нэр байна. Энэ нэрийн давтамжийг оноор үзүүлбэл: 1960-69 онд 2, 1970-79 онд 7, 1980-89 онд 33, 1990-99 онд 184 байна. Энэ нэрийг Гоомарал, Гуамарал гэж 2 янзаар бичжээ. Мөн Нууц Товчоонд гардаг Боржигидай мэргэний гэргий Монголжингго хатны нэртэй 34 хүн байгаагийн 28 нь 1990-99 онд төрсөн охид байна. Энэ нэрийг 1960 оноос өгч эхэлсэн ба бичиг баримтад Монголжингго, Монголжингуга гэж 2 өөрөөр бичжээ.

Чингис хааны авааль хатан Бөртэ хатны нэртэй 33 хүн байна. Энэ нэрийг 1987 онд нэг хүүхдэд өгч байсан бол 1990- 2000 онд 32 хүүхэд ийм нэрээр бүртгэгдсэн байна. Бөртэ хатны нэрийг Бөртэ, Бөртээ, Бөртө гэж 3 янзаар бичсэн байна.


Чингис хааны бага хатан, Уваш мэргэдтйн тэргүүн Дайр-Усуны охин, гоо үзэсгэлэнт Хулан хатны нэртэй 4077 хүн байна. Хатдын нэрээс Хулан хатны нэр хамгийн их давтамжтай нэрийн тоонд зүй ёсоор орж байна. 1916 онд төрсөн хүүхдэд энэ нэрийг анх өгсөн байна. Энэ нэрийн давтамжийг оноор үзүүлбэл: 1910-19 онд 2, 1920-29 онд 4, 1930-39 онд 7, 1940-49 онд 7, 1950-59 онд 21, 1960-69 онд 80, 1970-79 онд 234, 1980-89 онд 880, 1990-99 онд 2842 хүүхдэд энэ нэрийг өгчээ (5-р зураг).



5-р зураг. Хулан

Энэ нэрийг дангаар нь өгөхөөс гадна нийлмэл нэрийн эхэнд оруулж 2 үгээс бүтсэн нэр үүсгэж өгчээ. Энэ нэрээс: Хуланхатан, Хулангоо, Хуланзаяа, Хулансайхан, Хулансаран, Хуландарь, Хуланжаргал, Хуланшагай, Хуланцэцэг, Хулан-Эрдэнэ, Хуланбор гэсэн 11 нийлмэл нэр үүсчээ.

Чингис хааны хоёр дахь их хатан Татаар аймгийн их Чэрингийн охин Есүгэний нэртэй 24, Чингис хааны хатан, мөн их Чэрингийн охин, түүхэнд ухаант хатан хэмээн бичигдсэн Есүйн нэртэй 30, бүгд 54 охин 1990 оноос хойш төржээ.



6-р зураг. Тэмүүлэн

Тэмүүжиний охин дүү Тэмүүлэний нэр одоо цагийн хамгийн түгээмэл нэр болоод байгаа бөгөөд 1601 хүн энэ нэртэй байна.


1952 онд төрсөн хүүхдийг Тэмүүлэн гэж нэрлэснээр энэ нэр эхэлсэн байх ба нэрийн давтамжийг нь авч үзвэл: 1950-59 онд 1, 1960-69 онд 12, 1970-79 онд 37, 1980-89 онд 238, 1990-99 онд 1313 байна (6-р зураг).

2000 оноос хойш төрсөн ийм нэртэй охид эрс олширч, хамгийн их дэлгэрсэн нэрийн эхний гуравт орох болсон тухай өдөр тутмын сонин хэвлэлд бичиж байна. Жишээлбэл: 2000-2001 онд энэ нэрийг 226 охинд өгч байсан бол 2004 онд 284 охинд өгчээ /Өдрийн сонин 2004 он № 315/.

Чингис хааны есөн өрлөг сайдуудаас, хүлэг Боорчийн нэртэй 23, алдарт жанжин Сүбээдэйн нэртэй 20, Зэлэмийн нэртэй 14, Мухулайн нэртэй 4 хүн байна. Чингис хааны 88 гавьяатны нэг, мянганы ноён Зэвийн нэртэй 13 хүн, Чингис хааны өргөмөл дүү, Улсын дээд заргач Шихихутагийн нэртэй 17 хүн байна.

Их Юан гүрний сүүлчийн хаан бөгөөд 35 жил төр барьсан Тогоонтөмөр хааны нэртэй 116 хүн, Чингисийн угсааны сүүлчийн хаан Цахарын Лигдэн хааны (1604-1634) нэртэй 36 хүн байна. Эдгээр нэрийн ихэнхийг 1990-ээд оноос хойш төрсөн хүүхдэд өгчээ.

Их эзэн Чингис хаанаас хойшхи хаад, хатдын нэрийн дотроос нэлээд их давтамжтай байгаа нэр бол Мандуул хаан (1426-1467), Мандухай хатны нэр болно. 1474 онд Монголын хаан ширээнд суусан Мандуул хааны нэртэй 126 хүн байна. 1944 онд төрсөн хүүхдийг Мандуул гэж нэрлэснээр энэ нэр эхэлж байна. Түүний давтамжийг авч үзвэл: 1940-49 онд 2, 1950-59 онд 2, 1960-69 онд 2, 1970-79 онд 9, 1980-89 онд 45, 1990-99 онд 66 хүнд энэ нэрийг өгчээ (7-р зураг).




7-р зураг. Мандуул

Ард олны дунд домог болон мөнхөрсөн төрийн томоохон зүтгэлтэн Мандухай цэцэн хатны нэртэй 675 хүн байна. 1915 онд төрсөн хүүхдийг Мандухай гэж нэрлэснээр энэ нэр эхэлжээ. Энэ нэрийн давтамжийг онуудаар авч үзвэл: 1910-19 онд 1, 1930-39 онд 1, 1940-49 онд 6, 1950-59 онд 4, 1960-69 онд 17, 1970-79 онд 16, 1980-89 онд 246, 1990-99 онд 384 хүнд энэ нэрийг өгсөн байна (8-р зураг). Энэ нэрийг Мандхай,


Мандахай, Мандуухай, Мандухай гэх мэтээр иргэний бичиг баримтад 5 янзаар бичсэн байна. Мөн энэ нэрээс Мандхайцэцэн, Мандухайхатан, Мандхайужин гэсэн нийлмэл нэр үүсчээ.

Монголын эзэнт гурэн бутран мөхсөний дараагийн хэдэн зуун жилд төр барьж байсан хаад, хатдын дотроос Мандуул хаан, Батмөнх даянхаан, Мандухай цэцэн хатан нар Монгол улсыг нэгтгэхийн төлөө асар их зүтгэл гаргаснаараа түүхэнд мөнхрөн үлдсэн боловч Батмөнх гэдэг нэр монголчуудын дунд эртнээс түгээмэл хэрэглэгдсээр ирсэн учир Баянмөнх хааны нэрээр нэрлэжээ хэмээн ялган үзэх боломж хомс тул (Даянхаан гэдэг нэр байдгийг эс тооцвол) энэ нэрийн тухай энд тодорхой дурдсангүй.



8-р зураг. Мандухай


XVIII зууны үед Манж Чин улсын Төв Азид явуулж байсан түрэмгийллийг сөрөн зогссон гол хүчийг толгойлж байсан Зүүнгарын хаант улсын хаан, Монголын улс төр-цэргийн нэрт зүтгэлтэн Галдан бошогт хааны хатан, түүний хамтран зүтгэгч эх оронч Ану хатны нэртэй 2838 хүн байна. Ану хатны нэр давтамжаараа Хулан хатны нэрийн дараа 2-рт орж байна. Энэ нэрийг 1919 онд төрсөн хүүхдэд эхэлж өгсөн ба давтамжийг нь оноор үзүүлбэл: 1910-19 онд 1, 1920-29 онд 3, 1930-39 онд 7, 1940-49 онд 9, 1950-59 онд 10, 1960-69 онд 8, 1970-79 онд 41, 1980-89 онд 234, 1990-99 онд 2525 хүнд өгчээ (9-р зураг).



9-р зураг. Ану

Энэ нэрээс Анухатан, Анухаан, Анударь, Анухай, Ануужин, Анунаран, Анумаа, Анубаяр, Ануунгоо, Анузул, Анумарал, Анужаргал, Анухун, Анутөмөр, Анубум, Ануболд, Ануцэцэн, Анударь-Эх, Анударьмаа, Ану-Эрдэнэ, Анутөр, Ануンбаатар, Ану-Үжин, Ану-Учрал гэх мэт 40-өөд нийлмэл нэр үүсчээ.

Монгол дахь шашин соёлын сэргэн мандлын гол төлөөлөгч, анхдугаар богд Г.Занабазарын (1635-1723) нэртэй 147 хүн байгаа ба 1924 онд төрсөн хүүхдийг Занабазар гэж нэрлэснээр эхэлж байна. Энэ нэрийн давтамжийг онуудаар үзүүлбэл: 1920-29 онд 5, 1930-39 онд 6, 1940-49 онд 4, 1950-59 онд 5, 1960-69 онд 9, 1970-79 онд 24, 1980-89 онд 31, 1990-99 онд 63 хүн байна (10-р зураг).




10-р зураг. Занабазар

Монголын ард түмний 1755-1758 оны тусгаар тогтолын төлөө зэвсэгт бослогын удирдагчдын нэг, хотгойдын ноён Чингүнжавын (1710-1757) нэртэй 74 хүн байна. 1960 онд төрсөн хүүхдийг Чингүнжав гэж нэрлэснээр эхэлжээ. Энэ нэрийн давтамжийг онуудаар авч үзвэл: 1960-69 онд 2, 1970-79 онд 7, 1980-89 онд 25, 1990-99 онд 40 байна.

Өнөөгийн монгол хүний нэрийн санд эртний түүхэн хүмүүсийн нэрээс гадна XX зуунд ажиллаж амьдарч байсан хүмүүсийн нэр ч цөөнгүй байдаг. Эдгээр хүмүүс XX

зууны монголын түүхэнд гарамгай гавьяа байгуулж нэр нь мөнхрөн үлдсэн ажээ. Тухайлбал 1921 оны Монгол ардын хувьсгалын удирдагч, ардын цэргийн жанжин Дамдины Сүхбаатарын нэртэй 5010 хүн бүртгэгдсэн байна.




11-р зураг. Сүхбаатар

Энэ нэрийн давтамжийг оноор үзүүлбэл: 1910-19 онд 8, 1920-29 онд 20, 1930-1939 онд 133, 1940-49 онд 443, 1950-1959 онд 982, 1960-69 онд 1034, 1970-1979 онд 1138, 1980-1989 онд 864, 1990-2000 онд 388 хүн байна (11-р зураг).

Энэхүү зургаас үзвэл 1950-1979 он хүртэл Сүхбаатар гэдэг нэрийг ихээхэн өгч байгаад 1990 оноос хойш эрс буурсан байна. Өөрөөр хэлбэл МАХН-ыг үүсгэн байгуулагч, 1921 оны ардын хувьсгалын удирлагч Д. Сүхбаатарын нэр нь Монгол улс социалист өөрчлөлтийг хийж, социалист нийгмийг байгуулж дуусгах зорилт тавьж байсан ид үед ихээхэн нэр хүндтэй байсан бол 1990 оноос эхлэн социализм мухардалд орж, монгол улс ардчиллын замыг сонгон, үндэсний түүхэн ухамсар сэргэсэн нийгмийн үйл явцтай холбогдож цөөрөх болсон байна. 1990-ээд оноос эхлэн социализмын үеийн удирдагчдын нэр хүнд буурч, Их Монгол улсын хаадын нэрийг илүү сонирхох болсныг Чойбалсан, Цэдэнбал гэдэг нэрүүдээс ч харж болно (12, 14-р зураг).

1921 оны Ардын хувьсгалын анхны “долоо”-гийн нэг, БНМАУ-ын Ерөнхий сайд, Бүх цэргийн жанжин, Гадаад явдлын яам, Дотоод явдлын яам, Мал тариалангийн яамны сайд байсан, маршал Хорлоогийн Чойбалсангийн (1895-1952) нэртэй 50 хүн байгаа ба 1927 онд төрсөн хүүхдийг Чойбалсан гэж нэрлэснээр эхэлж байна.

Энэ нэрийн давтамжийг онуудаар үзүүлбэл: 1920-1929 онд 2, 1930-1939 онд 5, 1940-1949 онд 8, 1950-1959 онд 12, 1960-1969 онд 6, 1970-1979 онд 7, 1980-1989 онд 7, 1990-1999 онд 3 байна (12-р зураг).




12-р зураг. Чойбалсан

Үүнээс үзвэл Чойбалсан нэртэй хүний тоо монгол улсад нэг хүнийг тахин шүтэх үзэл хүчээ авч байсан 1940-60 он хүртэл хамгийн олон тохиолдож байгаа ба 1960-69 онд буурсан нь нэг хүнийг тахин шүтэх явдлын хор холбогдлыг ойлгож, түүний эсрэг тэмцэж байсан тухайн үеийн монголын нийгмийн байдалтай холбогдоно. Гэтэл 1970, 80-аад оны үед МАХН-аас Х.Чойбалсангийн үйл ажиллагааны эерэг талыг үнэлж, түүхэнд эзлэх байр суурийг нь дан хар, муу талаас нь үзүүлэхгүй болсонтой уялдаж 1970, 80-аад оны үед Чойбалсан нэртэй хүний тоо дахин нэмэгдэж байжээ.


1921 оны Ардын хувьсгалын партизан, төрийн зүтгэлтэн, 1940-1953 онд БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн даргаар ажиллаж байсан Гончигийн Бумцэндийн (1881-1953) нэртэй 231 хүн байна. Энэ нэр 1928 оноос эхэлсэн ба давтамжийг нь онуудаар үзүүлбэл: 1920-1929 онд 1, 1930-1939 онд 5, 1940-1949 онд 38, 1950-1959 онд 37, 1960-1969 онд 15, 1970-1979 онд 30, 1980-1989 онд 40, 1990-1999 онд 65 хүн байна (13-р зураг).

Бумцэнд гэдэг нэр 1940, 50-иад оны үед нэлээд нэмэгдэж, харин 1960-аад онд буурсан үзүүлэлт эндээс харагдаж байна. Үүний учир нь Чойбалсан гэдэг нэртэй үндсэндээ адил нийгмийн шалтгаантай юм. Х.Чойбалсан, Г.Бумцэнд нарын ажил амьдралын зам нь ойролцоо бөгөөд хоёулаа ардын журамт цэргийн удирдах албан тушаалаас эхлэн БНМАУ-ын төр засгийн өндөр албан тушаалд нэгэн үед хамт ажиллаж байсан бөгөөд бас нэгэн үед нас барсан байна. Энэ хоёр нэрийн давтамжийн ялгаатай тал нь 1990 оноос хойш гарч байна. Тухайлбал Чойбалсан гэдэг нэрийн давтамж илт буурсан бол Бумцэнд гэдэг нэрийн давтамж нэлээд нэмэгджээ. Үүнийг манай 1990-ээд оныхны дээрх хоёр түүхт хүнд хандаж байгаа хандлага, үнэлгээний нь тусгал гэж үзэж болно.



13-р зураг. Бумцэнд

МАХН-ыг 40 гаруй жил толгойлж, БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн дарга, Сайд нарын Зөвлөлийн даргаар ажиллаж байсан маршал Юмжаагийн Цэдэнбалын (1916-1991) нэрээр нэрлэсэн 424 хүн байна. Энэ нэрийн давтамжийг онуудаар үзүүлбэл: 1910-1919 онд 5, 1920-1929 онд 7, 1930-1939 онд 11, 1940-1949 онд 70, 1950-1959 онд 97, 1960-1969 онд 68, 1970-1979 онд 91, 1980-1989 онд 56, 1990-1999 онд 19, 2000 онд 2 хүн байна (14-р зураг).




14-р зураг. Цэдэнбал

24 настай Ю.Цэдэнбалыг 1940 онд МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгосны дараа Цэдэнбал нэртэй хүн эрс олон болсныг энэ зургаас харж болохоос гадна 1980-аад оноос энэ нэр огцом буурсан нь 1984 оны 8-р сард Ю. Цэдэнбалыг албан тушаалаас нь чөлөөлсөн үйл явдалтай холбогдох нь гарцаагүй.

20-р зууны монголчуудын нэрийн санд улс төр, нийгмийн зүтгэлтнүүдийн нэрээс гадна Монгол улсын баатар, хөдөлмөрийн баатруудын нэрээр нэрлэсэн нэр цөөнгүй тохиолдож байна. 1939 оны Халх голын дайн, 1945 оны чөлөөлөх дайны үед тодорсон БНМАУ-ын баатар Л.Аюуш (1922-1945), Ц.Олзвой (1914-1941), Л.Дандар (1915-1986) нарын нэрээс үүсэлтэй Аюушбаатар нэртэй 43 хүн 1947-2000 онд,

Дандарбаатар нэртэй 35 хүн 1952-1999 онд, Олзвойбаатар нэртэй 21 хүн 1950-1994 онд төрсөн байна. Мөн БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, алдарт хоньчин З.Очирын (1905-1973) нэрээс үүсэлтэй Очирбаатар нэртэй 65 хүн байна. БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, Ардын Их Хурлын депутататаар 3 удаа сонгогдсон, төрийн шагналт хоньчин С.Цогтгэрэлийн нэртэй 855 хүн байна. Энэ нэрийн давтамжийг онуудаар үзүүлбэл: 1910-19 онд 1, 1930-39 онд 1, 1940-49 онд 1, 1950-59 онд 27, 1960-69 онд 252, 1970-79 онд 245, 1980-89 онд 239, 1990-99 онд 89 байна (15-р зураг).



15-р зураг. Цогтгэрэл

Өөрөөр хэлбэл энэ нэрийн тоо 1960-89 оны хооронд илт өссөн нь Цогтгэрэл гуай 1959 онд БНМАУ-ын хөдөлмөрийн баатар болж, 1976 онд БНМАУ-ын төрийн шагнал хүртэж нэр алдар нь улс орон даяар мандсантай нь холбогдоно. Энд буй 855 нэр бүгд С.Цогтгэрэл баатрын нэрээс гаралтай гэж батлах нь хэцүү боловч уг нэрийн оны давтамж нэгэн үе эрс өссөнийг түүнтэй холбон үзэхээс өөр аргагүй юм.

БНМАУ, ЗХУ-ын баатар, сансрын нисэгч Ж. Гүррагчаагийн нэртэй 548 хүн байна. Үүнээс 1980-89 онд төрсөн 312 хүн байгаагийн 102 нь түүний сансарт ниссэн 1981 онд төржээ. 1990-99 онд төрсөн 111 хүүхдэд энэ нэрийг өгчээ.

Монгол улсын баатар цол хүртсэн алдар цуутай хүмүүсийн нэрээр хүүхдээ нэрлэсэн нь тэдний эх орон, ард түмнийхээ өмнө байгуулсан гавьяаг нь мөнхжүүлж, тэд нар шиг эх оронч, дайчин, алдар гавьяатай хүн болохыг хүсэн ерөөсөн бэлгэдлийн утгыг агуулж байгаа юм. Ийм нэртэй хүмүүсийн ихэнх нь 1940-1960 оны хооронд төрсөн байгаа нь германы фашизм, японы милитаризмын эсрэг эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын төлөө тууштай тэмцэж байсан монгол төрийн бодлого, нийгмийн сэтгэлзүйд буусан тусгал гэж хэлж болно.

Түүхэн хүмүүсийн нэрийн дотор, бүтэн овог нэрээрээ тохирч байгаа нэрүүд ч байна. Жишээ нь 1930 онд төрсөн хүүхэд Дамдины Сүхбаатар, 1981 онд төрсөн хүүхэд Хорлоогийн Чойбалсан гэдэг овог нэртэй байх жишээтэй. Үүнтэй холбоотойгоор 2010-аад оны үеэс Есүхэйн Тэмүүжин, Чингисийн Өгэдэй зэрэг нэрүүд гарч ирэх бололцоотой байна.

Монгол хүний нэрийн санд зөвхөн монголын түүхт хүмүүсийн нэрээс гаралтай нэр байгаад зогсоогүй орос зөвлөлтийн түүхт хүмүүсийн нэр цөөнгүй тохиолдож байна.

Дэлхийн II дайны дараахнаас, тодруулбал 1940-өөд оны сүүлч, 50-аад оны эхнээс монголчуудын дунд орос хүний нэр ихээхэн дэлгэрсэн нь ХХ зууны монгол хүний нэрийн нэгэн онцлог юм [4:96]. Энэ үзэгдэл зөвхөн монголд төдийгүй дэлхийн II дайны эцсээс эхлэн Европын бүх орнууд, АНУ, Латин америкийн орнууд, Австралид орос нэрийг маш их сонирхох болжээ [8:233]. Энэ нь фашист германы аюулаас хүн төрөлхтөнийг аварсан зөвлөлтийн ард түмний түүхэн гавьяатай холбоотой нь мэдээжийн хэрэг юм.

Монголчууд хүүхэддээ жирийн орос нэрээс гадна Оросын 1917 оны социалист хувьсгалын удирдагч, Орос Зөвлөлтийн цэргийн нэрт жанжнууд, ЗХУКН, Зөвлөлт төрийн зүтгэлтнүүдийн нэрийг өгч байжээ. Октябрыйн хувьсгалын удирдагч В. И. Лениний нэр овгоос гаралтай Володя, Владимира, Ленин гэсэн гурван нэр монголчуудын дунд дэлгэрчээ. Ленин гэсэн нэр 1941 он, 1947 онд 2 удаа тааралдаж байна. Владимир нэртэй монгол хүн 43 байгаагаас эхнийх нь 1924 онд, сүүлийнх нь 1990 онд төрсөн байна. Володя нэртэй 118 хүн байна. Ер нь монгол хүний орос нэрийг ажиглавал ихэнх нь орос хүүхдийн нэр байдаг. Бидэнд байгаа түүвэрт анхных нь 1917-03-03-нд төрсөн Олзвойн Володя гэдэг хүн байна. Октябрыйн хувьсгал ялахаас өмнө төрсөн энэ хүний нэрийг Лениний багын нэр гэж хэлэх боломжгүй боловч 1940-1950 оны оны хооронд Володя нэртэй хүн хамгийн олон төржээ.

Оросын цэргийн гарамгай жанжин А.В. Суворовын (1729-1800) нэртэй 10 хүн 1950-1958 онд, Зөвлөлтийн иргэний дайны баатар В.И. Чапаевын (1887-1919) нэртэй 4 хүн 1937, 1939, 1945, 1983 онд төржээ. ЗХУ-ын маршал, ЗХУ-ын 3 удаагийн баатар С.М. Будённый нэртэй 4 хүн 1940-1950 онд төрсөн бол ЗХУ-ын маршал, ЗХУ-ын 4 удаагийн баатар, Монгол улсын баатар Г.К. Жуковын (1896-1974) нэртэй 48 хүн байгаагийн эхнийх нь 1932 онд төрсөн бөгөөд 1939-1960 онд ихэнх нь төржээ. ЗХУ-ын хошой баатар К.Е.Ворошиловын (1881-1969) нэртэй 1957-1960 онд төрсөн 14 хүн байна. Зөвлөлтийн нам, төр, цэргийн зүтгэлтэн М.В.Фрунзе (1855-1925)-ийн нэртэй 3 хүн 1948, 1978, 1988 онд төржээ.

ЗХУ-ын нам төрийн зүтгэлтэн, генералиссимус И.В.Сталины (1879-1953) нэртэй 2 хүн 1941, 1969 онд төржээ. ЗХУ-ын нам төрийн зүтгэлтэн М.И.Калинины (1875-1946) нэртэй 13 хүн 1938 онд 1, 1939-1955 онд 11, 1978 онд 1 төржээ. ЗХУ-ын нам төрийн зүтгэлтэн С.М.Кировын (1883-1932) нэртэй 1955 онд төрсөн 1 хүн байна. ЗХУ-ын нам төрийн зүтгэлтэн В.М.Молотовын (1890-1986) нэртэй 14 хүн 1938-1960 онд төржээ. Мэлс (Маркс, Энгельс, Ленин, Сталин гэсэн 4 нэрийг хураасан хэлбэр) нэртэй 23 хүн 1940-1978 онд төрсөн байна. Мэлсчо (Маркс, Энгельс, Ленин, Сталин, Чойбалсан гэдэг 5 нэрийн хураангуйлсан хэлбэр) нэртэй 2 хүн 1946, 1963 онд төржээ.

Эдгээр нэрээс гадна Орос Зөвлөлтийн нэрт зохиолчид, эрдэмтдийн овгийн нэрээс гаралтай монгол хүний нэр байна. Оросын аугаа их яруу найрагч А.С.Пушкины (1799-1837) нэртэй 32 хүн 1941-1960 онд төрсөн байна. Зөвлөлтийн нэрт биологич эрдэмтэн И.В. Мичурины (1855-1935) нэртэй 3 хүн 1955-1956 онд гурвуулаа Дорнод аймагт төрсөн байна. Дэлхийн анхны сансрын нисэгч, ЗХУ-ын баатар Ю. А. Гагарин (1934-1968) нэртэй 26 хүн 1961-1980 онд төржээ. ЗХУ-ын баатар, анхны сансрын нисэгч эмэгтэй В.В.Терешковагийн нэртэй 2 хүн 1964 онд төржээ. 1981 оны 3-р сарын 22-30-нд Зөвлөлт-Монголын сансрын хамтарсан нислэгийн үед “Союз-39” хөлгийн даргаар ажилласан ЗХУ-ын хошой баатар, Монгол улсын баатар В.А.Жанибековын нэртэй 3 хүн Монгол хүн сансарт ниссэн 1981 онд төрсөн байна.

Товч дүгнэлт

1. Монголчууд үр хүүхэддээ нэр өгдөг олон төрлийн ёс заншилтай бөгөөд нийтэд алдаршсан түүхт хүмүүсийн нэрээр нэрлэх нь тэдгээрийн зөвхөн нэг нь л юм. Хэдийд, ямар хүний нэрийг хүүхэддээ өгч байгаа нь тухайн үеийн нийгмийн сэтгэл зүй, хувь хүмүүсийн үзэл бодол, тэр үеийн улс төрийн бодлого зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой байдаг учир эдгээр нэрийг зөвхөн хэл шинжлэлийн талаас нь судлах бус нийгэм улс төрийн нь өргөн суурь дэвсгэр дээр тавьж судлах шаардлага гардаг. Нэг нэр ч цаг үе бүхэнд өөр өөр сонголттой байдгийг өгүүлэлд дурдсан нэрүүдээс харж болохоор байна. ХХ зууны монгол хүний нэрийн санд түүхт хүмүүсийн нэрээр нэрлэсэн нэр дундажаар 200 хүний нэрэнд нэг тааралдаж байна.
2. ХХ зууны монгол улсын түүх, Зөвлөлт Холбоот Улс, социализм, коммунизмын үзэл санаатай нягт холбогдсон байдаг нийгмийн ахуй нөхцөл нь монгол хүний нэрийн санд орос нэр, түүний дотор Орос Зөвлөлтийн түүхт хүмүүсийн нэр орж ирэх нөхцлийг бий болгож байсан юм.
3. Түүхэн хүмүүсийн нэрийн давтамжийн хөдөлгөөнөөс харахад монгол улс хөрөнгөтний бус хөгжлийн замыг сонгож, социалист нийгмийг байгуулах зорилт тавьж байсан үед тэр үеийн монгол зөвлөлтийн томоохон удирдагчдын нэр олонтоо тохиолдож байсан бол 1990 оноос хойш социализм мухардалд орж, монгол улс ардчиллын замыг сонгон, үндэсний түүхэн ухамсар сэргэсэн нийгмийн үйл явцтай холбогдон Их Монгол улсын хаад, хатад, жанжнууд, үндэсний тусгаар тогтолын төлөө тэмцэгчдийн нэрийг илүү сонирхох болсон байна. Нэр тус бүрийн эзлэх хувийн жин, тэдгээрийн давтамж хөдөлгөөнийг тодорхойлов.
4. Түүхэн хүмүүсийн нэрийн дотор, бүтэн овог нэрээрээ тохирч байгаа нэрүүд ч байна. Үүнтэй холбоотойгоор 2010-аад оны үеэс Есүхэйн Тэмүүжин, Чингисийн Өгэдэй зэрэг нэрүүд гарч ирэх бололцоотой байна.

Ном зүй

1. Горбаневский М. (1987) В мире имен и названий. М.,
2. Никонов В.А. (1974) Имя и общество. М.,
3. Сэргээ Ж. “ХХ зууны монгол хүний нэрийн зарим онцлог” Ономастическое пространство и национальная культура. Материалы международной научно-практической конференции 14-16 сентября 2006 г. Улан-Удэ
4. Сэргээ Ж. (1992) Монгол хүний нэр. УБ.,
5. Монгол улсын түүх 5 боть. (2003) УБ.,
6. Золтоева О.Ф. (2006) “Онимическая лексика современного монгольского языка”. Улан-Удэ.,
7. Денисова В.В. “Универсалии монгольских антропонимов. Улан-Удэ 2004 г
8. Ономастика. Типология и стратиграфия (1988). М.

Summary

In this article we have picked out the names of historical figures which are among the collection of 2 million 300 thousand names and have looked upon its evolution through time.

It has been proven that approximately one historical figure's name is found among 200 names. If we look at the frequency dynamics of names in the years when Mongolia was heading towards socialism we can see that in those times the names of Mongolian and Soviet leaders, political, social and cultural figures have been used most often.

However, since the '90s, when Mongolia chose the brighter road to democracy there has been a certain interest in the names of kings, queens and warriors of the Great Mongolian State and the fighter for the national independence struggler. These statics are shown in numbers.